

Ядмаагийн Цэрэндагва<sup>1</sup>, Жоан Шнейдер<sup>2</sup>

<sup>1</sup>Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн,  
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайваны өргөн чөлөө,  
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр  
<sup>2</sup>АНУ-ын Калифорнийн Үндэсний Парк, Коларадогийн Цөлийн Дүүрэг

### Их Нартын чулууны хадны зураг: Алаг-Өндөр, Тахилгат цагааны ар цохионы шинэ дурсгал

**Хураангуй.** Энэ өгүүлэлд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг Их Нартын Байгалийн Нөөц газрын нутаг дэвсгэрээс 2010 онд илрүүлэн олж, 2013 онд нарийвчлан судалсан Алаг-Өндөр, Тахилгат цагааны ар цохионы хадны зургийн дурсгалыг нийтэлж байна. Тус хоёр газрын хадны зургийн дүр дүрслэлийн тодорхойлолтуудыг хийж, зохиомжийн онцлог талуудыг тогтоож, Монголын болоод хөрш зэргэлдээх бүс нутгийн хадны зургийн ижил төстэй дурсгалуудтай харьцуулан он цагийн хамаарлын асуудлыг тогтоохыг зорилоо. Алаг Өндөрийн хадан цохионы хоёр хэсэг газрын зургаан хадан гадаргууд 40 гаруй дүр, дүрслэл, Тахилгат Цагааны ар цохионд нэг газарт зургаан дүр дүрслэл сийлэгдсэн байна. Тэдгээр зургийг битүү хонхойлон сийлэх арга барилаар урлажээ. Хадны зургийн дүрслэлийн арга барил, зохиомж зэргээс харахад хүрэл зэвсгийн үе, дундад эртний улсуудын үед холбогдохоор байна.

**Түлхүүр үг.** *Их Нартын чулуу, Алаг-Өндөр, Тахилгат цагаан, хадны зураг, морьтон, янгир, завины дүрслэл, хүрэл зэвсгийн үе*

Tserendagva Yadmaa<sup>1</sup>, Schneider Joan<sup>2</sup>

<sup>1</sup>Institute of Archaeology,  
Mongolian Academy of Sciences Building-1, Peace  
avenue, Ulaanbaatar-13330, Mongolia <sup>2</sup>California  
State Parks, Colorado Desert District, USA

### Petroglyphs of the Ikh Nartiin Chuluu: New Rock Art Sites of Alag-Undur and Takhilgat Tsagaan

**Abstract.** This article presents the rock art images of Alag-Ondor and Takhilgat Tsagaan cliffs, discovered in 2010 and studied in detail in 2013 in the territory of the Ikh Nart Nature Reserve, Dalanjargalan soum, Dornogovi aimag. The purpose is to describe the rock art imagery in both places, identify the distinctive aspects of the design, and compare them with similar rock art from Mongolia and neighboring regions to determine their chronological placement. There are more than 40 figures and images pecked on six rock surfaces in two parts of the Alag Ondor cliff and six figures pecked in one place on the Takhilgat Tsagaan cliff. These images were made using the full-body pecked technique. Based on the style and composition of the rock images, they are related to the Bronze Age and the Early Middle Ages.

**Keywords.** *Ikh Nart, Alag-Ondor, Takhilgat Tsagaan, rock art, images of horse rider, ibex, boat, Bronze Age*

### Удиртгал

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Их Нартын Байгалийн Нөөц Газрын археологийн дурсгалыг бүртгэн баримтжуулах, хамгаалах зорилготой Монгол-Америкийн хамтарсан археологийн судалгааны экспедиц 2010 оноос эхлэн археологийн хайгуул судалгааны ажлыг Их Нартын чулуунд хийж эхэлсэн юм (Цэрэндагва, Шнейдер, 2014; Цэрэндагва, Шнейдер, Далантай, 2014; Цэрэндагва, Шнейдер, Далантай, 2015; Цэрэндагва ба бусад, 2016; Цэрэндагва ба бусад, 2017; Shneider, et.al., 2016; 2019; Rosen, et.al., 2019; Цэрэндагва ба бусад, 2020).

Судалгаа эхэлснээс хойш чулуун зэвсгийн үеэс ХҮП-ХҮШ зууны үе хүртэлх олон зуун археологийн дурсгалт газрыг илрүүлэн судлаад байна. Тэдгээр дурсгалуудын дотор хадны зургийн дурсгал цөөн боловч бий (Цэрэндагва, 2020). Их Нартын чулууны умардад орших цувраа хадан толгойн наран ээвэр талд нь янгир, адуу, нохой зэрэг араатан амьтнаас гадна хүн, тамга тэмдэг зэрэг олон тооны хадны зураг сийлжээ. Хоёр дахь зураг бүхий хад цувраа толгодоос өмнө зүгт холгүйхэн орших ба хадаг толгойн өвөр талын налууд нэг дор хэдэн янгирыг нэлээд өвөрмөц байдлаар цоолборлосон байна.

Эхний зураг бүхий хад Халзан уулаас зүүн хойш 3,9 км зайд, Алаг-Өндөр уулын баруун өндөрлөг талын дунд, Халзангийн рашаан Даланжаргалан сум орох замын баруун хажууханд байна (Зураг 1, а). Энд замын хоёр хажуугаар зүүнээс баруун тийш чигтэй, хоорондоо тодорхой зааг зайтай цувраа хадан тогтцууд байх ба замын баруун талын хүрэн занарлаг хадтай цувраа гурван намхавтар толгойн голын болон баруун толгойн энгэр хаднаа хэд хэдэн газарт тодорхой сэдэв зохиомж бүхий зургуудийг цоолборложээ. Гол хэсгийн харьцангуй өндөр толгойн урд энгэрийн ёроолын тэгш хаданд нэг бүлэг, баруун талын тармаг, намхавтар толгойн өвөр, зүүн хажуугийн босоо тэгшхэн хаданд хэд хэдэн бүлэг газарт хүн, амьтан, тамга тэмдэг сийлсэн байна. Зураг дүрсэлсэн хад нь нар салхины нөлөөгөөр ихэд элэгдсэний дээр хагарал маш ихтэй тул хадны зураг ихэд элэгдэж бүдгэрчээ. Зарим амьтны дүрслэлийн тал хэсэг ховхорч унасан байдалтай ч болсон байх ажээ.

Бидний толилуулан буй дурсгал нь Их Нартын хадан дахь одоогоор олддоод байгаа олон амьтныг нэг дор дүрсэлсэн цөөвтөр дурсгалын нэг юм. Их нартын чулууны боржин тогтцоос шалтгаалан хад чулуунаа зураг дүрслэл зурж үлдээх явдал түгээмэл биш байсан хэдий ч хэд хэдэн газарт сонирхолтой дүр дүрслэл, зохиомж, тамга тэмдгийн зүйлс, бичээс сийлэгдэн үлдсэн байдаг.

Зурагт хадны бэл дэвсгээр том, жижиг дөрвөлжин булш, урд хөндийд олон дөрвөлжин булш

байхын зэрэгцээ, хадны эргэн тойрноос чулуун зэвсгийн зүйлс, ваар савны хагархай нэлээд хэмжээгээр олддог нь эртний хүний ахуй амьдрал эрчимтэй өрнөж байсан газар байсныг батлан харуулж байна.

Алаг-Өндөрийн хадны зураг дүрслэлийн нэг онцлог бол амьтдын бүх биеийн ерөнхий тэгийг хонхойлон цоолборлох аргаар урласан байхын дээр амьтдын биеийн харьцааг ерөнхийдөө уртлаг байдалтай гаргасан явдал юм.

Хадны зураг бүхий хоёр дахь дурсгалт газар өмнөх дурсгалт газраас баруун урагш 1 км зайд байрлана. Тэгш өндөрлөгийн дунд сондгой тогтсон үелсэн том боржин хадны урд хажуугийн ёроолын зүүн тийш хандсан босоо тэгш толигор гадаргуу дээр нэг дор олон янгир, нэг тамга сийлээстэй бий (Зураг 1, б).

### Алаг-Өндөрийн хадны зураг

*1-р зураг.* Голын өндөр хадны хормойн урагш харсан тэгш толигор гадаргуу дээр цоолборлогджээ. Зүүн гар талд шовгор оройтой толгойн өмсгөл бүхий гараа унжуулан зогсож байгаагаар тоймлон харуулсан байна. Уг хүний толгой болон бүсэлхийн хажууханд жижиг дугуй цохижээ. Хүнээс зүүн тийш холгүйхэн урт соотон чихтэй, монхор хоншоортой, богино нарийн хөлтэй, уртлаг биетэй нэгэн амьтан дүрсэлсэн байх ба сүүлний хэлбэрээр нь нохой гэж танигдана. Уг нохойны зүүн доохон арагш нуруу дагасан урт эвэртэй, урт нарийн биетэй янгир дүрсэлжээ. Нохой болон янгирын дээхэн талын хадны гадаргууг дөрвөлжлөн холгчин хуулсан байна (Зураг 2, 1).

*2-р зураг.* Баруун хадан толгойн зүүн хажуугийн хүрэн улаан өнгөтэй том толигор хавтгайд зургаан сэртэнтэй онги (нар) тамга, том даргай эвэртэй тэх дүрсэлжээ (Зураг 2, 2).

*3-р зураг.* Дээр дурдсан зураг бүхий хадны гадаргуугийн залгаа урд талын хагарал ихтэй, налуувтар гадаргуугийн хамгийн доод талд нэг тэмээг зүүн тийш хандуулан тойм байдлаар дүрслэхдээ сүүлийг өтгөн, уртаар харуулжээ. Тэмээний дээхэн талд өтгөн сүүлийг газарт шүргүүлсэн адууны дүрслэл тодорч харагдана. Биеийн тигийг уртавтар, намхавтар гаргаад сүүлийг газарт шүргэсэн байдлаар харуулсан байна. Хүзүүнээс богиновтор, өргөн зүйл унжсан байгаа нь тод харагдана. Хадны төв хэсгийг эзлүүлэн гурван адуу, хоёр зээр, нэг солжир эвэртэй янгир, өөр хоёр амьтны дүрс зэргийг сийлсэн байна.

Солжир эвэртэй янгирыг шодон сүүлтэй адууны урд хөл дамнуулан сийлсэн ажээ. Хадны ховхорлт хагарлаас шалтгаалан доод талын урт биетэй, соотон чихтэй, урт нарийн хоншоортой адууны ард байх хоёр амьтны дүрс сайн танигдахгүй болжээ. Эврийн хадгалагдан үлдсэн байдлаас харахад



Зураг 1. А) Хадны зургийн дурсгалт газруудын байр зүйн зураг (Газрын зургийг үйлдсэн Д.Содномжамц)  
Б) Алаг-Өндөрийн хадны зургийн дурсгалын харагдах байдал В) Тахилгат Цагааны ар цохионы хадны зургийн дурсгалын харагдах байдал

адууны хондлой дагуулан толгойг нь дүрсэлсэн янгир боллолтой. Харин адууны хөл тушаа дүрслэгдсэн амьтныг тодорхойлох боломжгүй байна. Хадны дээд талд хөлөө нугалан хэвтэх янгир болон хүзүүгээ сунган зогсох янгирыг цоолборлосон байна (Зураг 2, 3).

4-р зураг. Өмнөх зураг бүхий хадны залгаа хажуу талын, бага зэрэг дээш товойн гарсан, мөн л хагарал ихтэй талбайд олон тооны дүрслэлүүд сийлээстэй байна (Зураг 3, 1). Хадны төв хэсгийн дээд талд голоороо нумарсан байдалтай, дээрээ өргөн найман салаатай тун сонирхолтой дүрслэл байна. Түүний доохон талд урт матигар эвэртэй нарийн цүүцгэр хөлтэй тэхийг үл мэдэг тонгойсон байдалтайгаар сийлжээ. Хадны төв хэсэгт дөрвөн дүрслэл байна. Энд данхар махир эвэртэй тэхийг уруу харуулан дүрсэлсэн байх ба хөлийн тал, бөгсөн бие дүрсэлсэн хад ховхорч унажээ. Янгирын өөдөөс харуулан урт сүүлтэй, сэрвээ өндөрдүү, толгой жижиг араатан амьтныг (ирвэс?) дүрсэлсэн байх ба янгирыг нуруугаар нь доош харуулсан байдлаас харахад араатанд бариулсан байдлыг харуулах зорилгоор ийнхүү өвөрмөц аргаар урласан бололтой. Тэдгээрийн доод талд нэгэн морьтон зогсох ба түүний урд талд гараа алдлан хөлөө алцайн зогсох хүний дүрслэлтэй. Зэрвэс харахад морьтныг хөтлөн зогсох хүн гэж харагдах хэдий ч хадны зургийн өнгөнөөс харахад морьтны дүрслэл хадныхаа өнгөнөөс ялгагдах аргагүй болсон бол харин хүний сийлбэр өнгө харьцангуй цайвар байгаа явдал нь өөр өөр цаг үед бүтээгдсэнийг харуулна. Өөрөөр хэлбэр хүний дүрсийг хожим нэмж сийлсэн байна.

Хадны баруун талд адуу амгайвчлан барьж зогсож буй хүний тойм дүрс байна. Уг хүний хүйсийг тодотгон харуулжээ. Энэ дүрслэлийн баруун хажууханд гурван амьтныг дээрээс доош цувуулан цоолборлосон байх ба дээд талынх нь чоно, нохой аятай соотой чихтэй хэдий ч сүүлэн хэсэг нь ховхорч мэдэгдэхгүй болсон байна. Бусад амьтдын дүрслэлийн зарим хэсэг хад ховхорсон тул чухам ямар амьтад болох нь сайн мэдэгдэхгүй, таамаглах төдий болжээ.

Хадны зүүн талд гурван адуу, тэдгээрийн хооронд давхиж яваа зээрийн дүрслэлтэй. Эхний адууны бахим том цээж, урт соотон чихийг ихэд онцлон харуулахыг зорьсон бол доод талын хоёр дахь адууны хондлойг ихэд томоор харуулсны дээр бөхөн толгойтой, нарийн чихтэйгээр урлажээ. Мөн нэг онцлог нь хойд урд хөлийг тушсан байдалтай зурсан явдал юм. Гурав дахь адууны толгой, хүзүүний тал хэсгийн хад ховхорч унасан нь дүрслэлийг бүхэлд нь харах бололцоогүй болгосон хэдий ч сүүлийг ихэд өвөрмөцөөр харуулсан онцлогтой. Адууны хооронд байх зээрийг жижгээр тэнхээ мэдэн харайж байгаагаар дүрсэлжээ.


Хадны доод хэсэгт хоёр янгирыг дүрслэхдээ нэгийг гурван хөлтэйгөөр, сүүлээ өргөснөөр харуулсан онцлог ажиглагдах ба нөгөө эсрэг харсан янгирын эврийг шорон хэлбэртэй ихэд урт гаргаад гэдсэн биеийг төмбийлгөн, сүүлийг өргөн эргүүлснээр харуулсан байна.

5-р зураг. Богино махир эвэртэй, урт сүүлээ өргөн модойлгосон хоёр янгирын дүрслэл (Зураг 3, 2).


6-р зураг. Нарийн урт хоншоортой, урт сэлмэн босоо эвэртэй, бүдүүн хүзүүтэй тэхийг тайван зогсож байгаагаар сийлсэн байна. Түүний нурууг тэгш, хэвлийг шавхнуун байдлаар харуулахыг зорьжээ (Зураг 3, 3).

#### Тахилгат цагааны арын хадан цохионы зураг

Тахилгат цагаан уулын ар хөндийд байх сондгой ганц хадан цохионы зүүн урд талын босоо хавтгай хадан гадаргууд нэг дор таван янгир, нэг тамга сийлжээ. Ингэхдээ дөрвөн янгирыг нэг арга барилаар зурсан нь онцгойрон ялгарч харагдана. Янгир дүрсэлсэн арга өвөрмөц, нэг янгирын



Зураг 2. Алаг Өндөрийн хадны зураг



Зураг 3. Алаг-Өндөр (1-3), Тахилгат Цагааны ар цохионы (4) хадны зураг

нуруунаас ташуу урт зураас, нэгний толгойноос нумарсан урт зураас татсан нь сонирхолтой. Тамганы хувьд “чөдөр” маягийн хэлбэртэй ч хоёр салаа хэсгийг шулуунаар, нөгөө үзүүрийг битүү гогцоолдуулан гаргасан, нумарсан хэлбэртэй харуулжээ (Зураг 3, 4).

#### Хадны зургийн өгүүлэмж, утга санаа, харилцан хамаарал

Алаг Өндөрийн хадны зургийн дотор тодорхой өгүүлэмж бүхий зураг хэд хэд байна. Эхний зохиомж бүхий зурагт хүн, нохой, янгир, хоёр дүр бий. Энд хүнийг өндөр оройтой малгай өмссөнийг тодорхой үзүүлжээ. Биеийн ерөнхий төрх, гар хөлийг тойм төдий дүрсэлдэг уламжлалт аргаар гаргасныг тод харж болно. Неолитын төгсгөл, хүрэл зэвсгийн эхэн үеэс эхлэн хүнийг тоймлон зурах хандлага дэлгэрч эхэлсэн байдаг бөгөөд энэ хандлага ч Алаг-Өндөрийн хадны зурагт илэрхийлэгджээ.

Уг зурагт дүрслэгдсэнээр тухайн үеийн хүмүүс өндөр оройтой малгай өмсөж байсныг улируулан харж болохоор байна. Монголын өндөрлөгийн эртний гөрөөчин, нүүдэлчдийн дунд өндөр оройтой малгай духдуулах уламжлал ямартай ч хүрэл зэвсгийн үеэс улбаатайг энэ зураг харуулж байна. Алаг-Өндөрийн хадны зурагт ийм малгай өмссөн хүнийг дүрслэн харуулсан явдал бол Их Нартын хүрэл зэвсгийн үеийн хүмүүсийн хувцасны соёлыг улируулан авч үзэхэд чухал ач холбогдолтой юм. Цаашид эртний монголчуудын хувцас зүүсгэлийн соёлыг судалдаг судлаачид Монголын хадны зурагт дүрслэгдсэн толгойн өмсгөл, малгайны талаар лавшруулан судалбал дорвитой судалгааны үр дүн гарах нь дамжиггүй. Монголын хадны зургийн бусад дурсгалд ч дээрхийн адил малгай төдийгүй өөр олон янзын малгай өмссөнөөр дүрслэгдсэн хүний зураг элбэг байдаг билээ. Алаг-Өндөрийн малгайтай хүнтэй адилхан зураг дүрслэл Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвшийн хадан хоёр удаа дүрслэгдсэн байдаг (Окладников, 1980: 248. Табл. 148, 13; 250. Табл. 150, 10). Мөн төстэй хүний дүрслэлүүд Шивээт хайрханы Хар салаа (Кубарев, 2009: 65, 111, 157, 341)-гийн хадны зурагт байна.

Хүнийг тойм дүрсэлсэн хэдий ч нохойгоо дагуулан тайван алхаж буй байдлыг харж болохоор байна. Харин нохойны доор буй янгирыг хожим нэмж

дүрсэлсэн нь хадны зургийн өнгөний ялгамжаас харагдана. Янгирын эврийг хойш налуулан шулуун татсан байх ба сэрвээг бугатай төстэй өндөр гаргасан байх ажээ. Нохойны ар болон дээд талд битүү хонхойлон цохисон тэгш өнцөгт хэлбэрийн дүрс өөрийн эрхгүй сонирхол төрүүлнэ. Энэ чухам ямар учиртай дүрслэл болох нь таамаг төдий байгаа ч нэг талаас аливаа зүйлийн хэлбэр хэмжээсийг урлах геометрийн дүрслэлийн улбаа байж болмоор байна. Нөгөө талаас авч үзвэл, ямарваа нэгэн том амьтны эх биеийн дутуу дүрслэл ч гэж харж болохоор аж. Энэ зурагт тодорхой үйл явдлын өрнөл харагдахгүй хэдий ч зохиомжийн гол дүр нь дээрх гурван дүрслэл гурвуулаа байгаа нь тодорхой аж. Энэ зургаас араатан амьтад, хүн хоорондын харилцан шүтэлцэл, амар амгалан байдлыг харж болно. Харин тэдгээрийн дээр байх утга тодорхой бус орон зайн хэмжээст хоёр том дүрс түгшүүрт мэдрэмж төрүүлэхээр харагдана. Амар амгалангийн дээгүүр хуралдсан аянга цахилгаант аадрын аймшигт хар үүлсийг ч санагдуулах мэт. Ямартай

ч хадны зураг урлалд ховорхон тохиолдох нууцлаг дүрслэлүүдийн нэг ийнхүү Их Нартын чулууны Алаг Өндөрийн хаднаа сийлэгджээ.

Дараагийн зурагт нарны бэлгэдэл дүрсийг янгиртай хамт нэг дор зурсан байна. Нарны дүрсийг охорхон зургаан цацрагтайгаар урлажээ. Нарны бэлгэдэл дүрс монголын хадны зурагт хүрэл зэвсгийн үеэс эхлэн дүрслэгдэж эхэлсэн байдаг. Нарны бэлгэдэл дүрсээс улбаалан хожим онгин тамга нүүдэлчдийн ахуйд хүчтэй нэвтэрсэн хэмээн үзэж болно. Янгирыг нартай хамт дүрсэлсэн тохиолдол Монголын хадны зургийн дурсгалд түгээмэл тааралддаг. Бидний гарт байгаа хэрэглэгдэхүүнээс харахад нарны дүрслэл, наран шүтлэгийн эртний илэрхийлэл болох онгин дүрстэй хамт зурагдсан янгир Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Шивээт хайрханы Хар салаа I, Хар салаа IV (Кубарев, 2009: 62, рис. 53; 143, рис. 361), Хар чулуу (Кубарев, 2009: 316, рис. 1023) Завхан аймгийн Баянхайрхан сумын Түвд (Цэвээндорж, 2020: 308, табл. 44, 1), Увс аймгийн Сагил сумын нутаг Можоо (Цэвээндорж, 2002: 326, табл. 62, 18), Хамуут (Цэвээндорж, 2002: 347, табл. 83, 61), Архангай аймгийн Ихтамир сумын нутаг Хөрөөгийн үзүүр (Гантулга, Ерөөл-Эрдэнэ, Магай, 2018: 141, 158, 159), Төв аймгийн Лүн сумын нутаг Авдарбаян уул (Окладников, 1981: 121, табл. 37), Тэвш уул (Окладников, 1980: 257-Табл. 157, 2) зэрэг олон газрын хадны зурагт бий.

Аглаг цагааны нэгэн зурагт хоёр хүн дүрслэгдсэн байна. Хүний дүрслэлээс харахад ахуйтай нягт холбоотой нь харагдана. Эхний хүн адуу амгайвчилсан эсвэл цоровдсон байдалтай зогсоно. Уг хүнийг хүрэл зэвсгийн хадны урлагт дүрсэлдэгчлэн болхидуу тойм төдий зурааслан сийлж харуулсан аж. Эр хүйсийг онцолсон байна. Зүүн гарын алга дагуулан өөр гурван амьтан дээрээс доош цувруулан сийлсэн байгаа нь ч зохиомжийн өвөрмөц шийдэл аж. Хэдийгээр тэдгээр амьтад сайн ялгарч танигдахгүй ч гэсэн дээд талд сүүл гаргаагүй нохой байна. Мөн доод талын хоёр амьтан ч нохой баймаар аж. Өөрөөр хэлбэл, энэ зурагт гурван нохой дагуулсан хүн, морь хөтлөн зогсох үйл явдал зохиомжлогджээ. Уг зурагтай нэгэн хавтгайд соотон чихтэй морь унан гараа алдалсан морьтныг хөтөлж зогсоо мэт харагдах хүн дүрслэгдсэн байна. Гэвч морьтныг хөтөлсөн бус харин морьтноос хожуу үед нэмж зурсан болох нь зургийн өнгөний ялгаатай байдлаас тодхон харагдана. Энэ хүнийг дээр дурдсан хүнтэй нэг арга барилаар тун төстэй урласан ажээ. Морьтныг бүрх малгай өмссөн мэт харагдахуйцаар урласан байна. Хадны зургийн урлагийн дурсгалд морьтныг олон янзын арга барил, хэв маягаар дүрслэн үзүүлдэг байсан нь морьтон хадны зураг урлалын онцгой, түгээмэл дүр байсны илэрхийлэл юм. Их

Нартын морьтонтой төстэй аргаар урласан зураг, дүр дүрслэл Увс аймгийн Наранбулаг сумын Шар булгийн онц (Дорж, Новгородова, 1975: 64), Ховд аймгийн Үенч, Алтай сумын зааг Ямаан ус (Дорж, Новгородова, 1975: 70) зэрэг олон газрын хаднаа бий.

Ямартай ч адуу хөтөлсөн хүний зургаас Их Нартын чулуунд хүрэл зэвсгийн үе гэхэд адууг гаршуулсан байсан нь тодорхой байна. Монголын Говийн бүс, Алтай, Хангайн хадны зурагт адуу гаршуулсан үеийн хадны зураг зохиомж нэн элбэг тааралддаг. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Бичигтийн ам (Сэр-Оджав, 1987; Цэрэндагва, Цэвээндорж, 2025), Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших Дэл уулын зүүн Билүүн (Цэвээндорж, Батболд, 2005:34, 42), Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Цагаан салаа-Бага Ойгор (Кубарев, Цэвээндорж, Якобсон, 2005: 588), Суман голын Салхитын хойд тохой (Санжмятав, 1995: Таб 72, 6), Тэвш (Окладников, 1980: 268. Табл. 168, 2) болон бусад газрын хадны зургийн дурсгалуудад адуу хөтлөн яваа, зогсоо хүний зураг дүрслэгдсэн байдаг. Хүрэл зэвсгийн үеийн хадны зургийн тусгай төрөл болох хадны зосон зургийн дурсгалуудад адуу морь хөтөлсөн хүний дүрслэл элбэг байдаг. Газар зүйн олон янз байдлын бүс нутгуудад ийнхүү адууг гаршуулсан байдлыг илтгэн харуулах зураг олноор дүрслэгдсэн байгаа нь Монголын өндөрлөг бол адуу гаршуулсан голомт нутгийн нэг гэдгийг илтгэн харуулж байгаа явдал юм.

Адууны дүрслэл Алаг-Өндөрийн хадны зургийн голлох дүрслэлийн нэг юм. Нийт адууны найман дүрслэл байна. Тэдгээрийн дөрвийг нэг дор олон янгир, зээр, тэмээний зургийн хамт, дөрвийг янгир, завь, морьтон, хүний дүрстэй хамт дүрсэлсэн байна. Бүх адууг өөр өөрийн онцлог төрхтэй, бие биеэсээ ялгагдах байдалтай дүрсэлсэн ажээ. Эхний зурагт дүрслэгдсэн дөрвийн хоёрыг өөд өөдөөсөө харсан байдлаар нуруу хондлойг шулуун үзүүлж, сүүлийг адилхан шодон байдлаар гаргажээ. Харин нэгний хөлийг бодитоор дөрвүүлэнг харуулсан бол нөгөөгийнхийг давхарласан байдлаар зурсан байна. Бусад хоёр адууг дээрхийн адилаар бодитоор дөрвөн хөлийг цохон сийлсэн байна. Энд зурагдсан нэг адууны хүзүүнд богино зураас унжсанаар дүрсэлсэн нь анхаарал татах ба сүүлийг газарт шүргэсэн байдлаар, сэлдийг тодотгон харуулсан онцлогтой. Бусад адууг бахим том цээжтэй, зузаан хондлойтой, сүүлээ сөхсөн гэх мэт өөр өөрийн өвөрмөц төрхийг тодотгон дүрсэлсэн байна.

Их Нартын хадны зураг дахь адуутай төстэй, нэгэн арга барилаар дүрсэлсэн зургууд Монголын хадны зургийн дурсгал дотор нэн түгээмэл юм. Том толгой, бахим бүдүүн цээжтэй адуутай ижилсэх зураг Чулуут голын Алаарын гол (Окладников, 1981б: 101, табл.58-3)-ын хадны зурагт байна.

Алаг-Өндөрийн хаданд арван дөрвөн янгир, Тахилгат Цагааны арын хадан цохионд таван янгирыг нэг дор дүрслэн үлдээжээ. Их Нартын чулуу бол янгирын голомт нутаг юм. Одоогийн байдлаар Их Нартын чулуунд 1000 гаруй янгир идээшин амьдарч байна. Янгирын зураг ийнхүү Их Нартын чулууны хоёр газарт олноор дүрслэгдсэн нь эрт цагаас эхлэн энэ сайхан нутагт янгир нутаглаж, түүхэн цаг үеийн турш ан агнуурын гол тусгал, шүтлэг бишрэлийн гол дүр болж ирснийг илтгэн харуулна. Бидний судлан буй зурагт ан агнуурын сэдэв зохиомжтой зураг байхгүйг дээр дурдсан билээ. Энэ нь магадгүй тус хаданд шүтлэг бишрэлийн үүднээс тодорхой агуулга бүхий зураг цоолборлон сийлж байсан байж магадгүй гэсэн таамаг дэвшүүлэхэд хүргэж байгаа юм. Энэ үүднээс ямартай ч хүрэл зэвсгийн үеийн тодорхой нэгэн мөчлөгт “янгир шүтлэг” овог аймгийн дунд түгэн дэлгэрч байсан бололтой. Улмаар дундад эртний улсуудын үед янгир шүтлэг дахин дэлгэрч овог аймгийн шүтээн, овгийн тамга болсон ажээ. Энэ үеийн Эшир (Мөнхтулга, Бүрэнтөгс, Арьяажав, 2019: 12-13) овгийн голлох янгир тамгатай дүйхүйц дүрслэл Тахилгат Цагааны арын хадан цохионд сийлэгдэн үлдэж хоцорсныг бид харж байна. Нэг дор таван янгир дүрсэлсний нэгийн нуруунаас ташуу зураас, өөр нэгийн эврийн угаас арагш богино зураас сөргийлгөн гаргасан байгаа нь сонирхолтой байна. Энд дүрслэгдсэн нарийн зурааслан урласан тавиу, зэгзгэр хөлтэй янгиртай төстэй дүрс Цагаан салаа, Бага Ойгор (Кубарев, Цэвээндорж, Якобсон, 2005: 506), Шивээт хайрхан (Кубарев, 2009: 279), Авдарбаян (Окладников, 1981: 120, Табл. 36-6) болон монголын тэгш өндөрлөгийн ихэнх хадны зургийн дурсгал дотор байдаг.

Эргэсэн урт сүүлтэй, даргар хоёр эврийг тодотгон үзүүлсэн янгир, богино махирдуу эвэртэй хос янгирын дүрслэлтэй төстэй зургууд Булган аймгийн Орхон сумын нутаг Баруун могой (Окладников, 1981: 97, Табл. 13-4), Уулын Алтай Калбак Таш (Кубарев, 2011: 344)-ын хадны зурагт тааралдаж байна.

Алаг-Өндөрийн хадны зураг дахь нэг өвөрмөц дүрслэл бол босоо богино, өргөвтөр найман сэртэнтэй “завь” хэлбэрийн дүрслэл юм. Энэ дүрслэлийн хөндлийн доод тал нь голоороо бага зэрэг хотгор дээд тал нь гүдгэр бөгөөд хоёр захын сэртэнгийн нэг нь шулуун гадагш налуу бол нөгөө нь нумарсан хэлбэртэй харагдана. Дээд захын хоёр сэртэн зураасны хооронд зургаан босоо зураас гарган дүрсэлжээ. Энэ дүрслэл нь Зүүн хойд Ази, Сибирь, Карелийн хадны зурагт түгээмэл тааралдах завьтай хүмүүсийн зургийг өөрийн эрхгүй санагдуулна. Гэхдээ Монголын говь тал хээрийн хагсуу, гандуу уур амьсгалтай бүс нутгийн хад чулуунаа ийнхүү дүрслэгдсэн явдлыг дээр

дурдсан газруудад буй завь хэлбэрийн дүрслэлтэй адилтган авч үзэх нь учир дутагдалтай хэдий ч дүрслэлийн арга барил, харагдах байдлаараа яах аргагүй жишиж үзэхээс өөр аргагүй байна. Манай орны хадны зургийн дурсгал дотор дээрхтэй төстэй ганцхан дүрслэл Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант хайрхнаас олдсон байна (Цэвээндорж ба бусад, 2004: 276). Судлаачид энэ төрлийн зургийг завьтай хүмүүсийн дүрслэл хэмээн үздэг бөгөөд томоохон нуур, далай тэнгисийн эрэг орчмын хадны зургийн дурсгалд голчлон тохиолддог. Алс Дорнод Чукоткийн Пыгтымелийн хадны зурагт энэ төрлийн зураг олон тоотой бий (Диков, 1971). Мөн энд хөнгөн каяк завин дээр ганцаар суун сөрлүүрт жад барин загас агнаж буй, завиа сэлүүрдэн буй байдлыг харуулсан бодит дүрслэлүүд ч нэлээд байдаг. Якутын Олёмма голын савын Чара, Арби, Токко, Басынай, Олёмма зэрэг газрын хадны зургийн дурсгалд 12 завины дүрслэл дүрслэгдсэн байдаг (Окладников, Мазин, 1976). Тэдгээр завин дээр богино өргөвтөр зураасаар зэрэгцэн суугаа 4-18 хүнийг тоймлон дүрсэлжээ. Завины өөхийг тэгш, гүдгэрдүү, хотгор дүрсэлсэн байдаг ба Аглаг Өндөрийн дүрслэл шиг хотгор өөхийтэй дүрслэгдсэн завины дүрслэл ч бий (Окладников, Мазин, 1976: 164, табл. 42-1). Алс Дорнодын Сакачи-Аляны хадны зурагт гурван завины дүрслэл байгаагийн хоёрын өөхий нь Их Нартынхтай төстэй байна (Окладников, 1968: 43). Сибирийн Томь голын цутгал Писаная голын эрэг дагуух хадны зургийн дурсгалд 11 завь дүрслэгджээ (Мартынов, 1966). Якутын Алдан голын сав дагуух Маягийн хадны зургийн дурсгал дотор Их Нартын чулууны завьтай адил зургаан хүн сууснаар дүрсэлсэн нэг зураг байна (Окладников, Мазин, 1979: 138, табл.51-5). Энэ мэтчилэн Алс Дорнодоос эхлэн Сибирь дамнан Скандинавын хойг хүртэлх асар өргөн уудам бүс нутагт одоогийн байдлаар завь дүрслэгдсэн 60 орчим гаруй дурсгалт газар илэрч олджээ (Куликова, 2014). Тэгэхээр хүрэл зэвсэг, төмөр зэвсгийн эртний нүүдэлчид, анчин, загасчдын үлдээсэн хадны зургийн нэг голлох сэдэв нь завь, завь сэлүүрдсэн хүмүүс, завин дээр олноор суусан хүний дүрслэл байсан нь тодорхой юм. Манай орны хадны зургийн гол сэдэв нь ан агнуур, араатан амьтад, эд зүйлс, эдлэл хэрэглэл, овог аймгийн тамга тэмдэг, хүн, хүний харилцааны өргөн хүрээтэй сэдэв байдаг боловч онцгой, содон, ховорхон зохиомж бүхий сэдэв, дүрт зургууд цөөнгүй дүрслэгдэн үлдэж хоцорсны нэг нь энэхүү “завь” хөлөглөсөн хүмүүсийн дүрслэл хэмээн үзэж байна. Төв Азийн өндөрлөгт хүрэл зэвсгийн үед оршин амьдарч байсан эртний анчин-нүүдэлчид алс хол нүүдэллэн, аялан явж, эргэж нутгаа зорин ирж хад чулуунаа өөрсдийн үзэж харсан сонин содон зүйл болох “завь” хөлөглөсөн хүмүүсийг ийнхүү

мөнхлөн үлдээсэн байх ч магадлалтай билээ. Энэ утгаараа дурдан буй дүрслэл нь нэг талаар эртний түүхийн тодорхой үе дэх хүмүүсийн алс газар, шинэ нутаг усыг зорин тэмүүлэх хүсэл эрмэлзлийн илэрхийлэл болон Их Нартын хаднаа мөнхрөн үлдсэн байж болох юм. Мөн энэхүү зураг нь Баянборын нуурын хотгорын арын өндөрлөгт байх ба эрт цагт энэ хотгор усаар дүүрэн мэлтэлзсэн том нууртай байгаад уг нуурын эрэг хөвөөгөөр оршин амьдарч байсан овог аймгийнхан завь хөлөглөн байсныг ч үгүйсгэх аргагүй юм.

### Зураг дүрслэлийн онцлог, он цагийн асуудал

Алаг-Өндөрийн хадны зургийн дүр дүрслэлүүдэд орон нутгийн шинжтэй онцлогууд ажиглагдана. Юуны түрүүнд, амьтдыг нэлээд уртлаг сунагар байдлаар дүрслэх хандлага тод харагдана. Нохой дагуулан алхаж яваа хүн бүхий зурагт нохой болон янгирыг дээр дурдсанаар дүрсэлсэн байна. Нохойн соотон чихийг ихээхэн онцолж, далбагар томоор харуулжээ. Сүүлийг богино, шодон маягтай дүрсэлсэн өөр нэг онцлог адууны зурагт байна. Адууны бусад дүрслэлийг ч мөн уртлаг байдлаар харуулсан байна. Адууг ийнхүү урт биетэй дүрсэлсэн явдал Зүүн хойд Азийн хадны зургийн дурсгалд олон бий. Онцлон дурдахад Хакасийн Усть Тубагийн хадны зурагт тун төстэй нэгэн адууны зураг байна. Хэдийгээр энэ хоёр газар хоорондоо асар хол орших хэдий ч эртний урлагийн дүрслэх арга барил адилсаж буй нь хүрэл зэвсгийн үеийн хүмүүс оршин байсан газраасаа үл хамаарсан зураг урлалын нийтлэг уламжлал, чиг хандлагатай байсныг илтгэн харуулах баримт гэлтэй. Алаг-Өндөрийн хадны зургийн өөр нэг онцлог бол цоолборын хадгалалтын өнгө харилцан адилгүй байгаа явдал юм. Зарим зураг хадны өнгө гялтгаас ялгагдахгүй хүрэн бор болсон бол зарим дүрслэл цайвар цагаандуу байна. Энэ нь мэдээж уг дүрслэлүүд харилцан адилгүй цаг хугацаанд бүтээгдсэнийг харуулах чухал сэжүүр юм.

Хадны зургийн он цагийг тогтоон тодорхойлох нь судлаач хүний шийдэх хамгийн ярвигтай асуудлын нэг байдаг. Хадны зурагт дүрслэгдсэн дүр, дүрслэлийн урласан арга барил, хадгалалтын байдал, сийлбэр өнгөний хувирал, ялгарал, ялгаа, давхардсан зургийн байр байдал, нэгэнт тогтсон тодорхой шалгуур, бусад газраас илэрч олдож он цагийн асуудлыг тодорхойлон тогтоосон ижил төрлийн хадны зургуудтай харьцуулах зэргээр хадны зургийн он цагийн асуудлыг тогтоон тодорхойлон авч үздэг. Дээр дурдсан бүх арга ажиллагааг удирдлага болгон Их Нартын Алаг-Өндөр, Тахилгат Цагааны хадны зургийн нас, хамаарах цаг хугацааг баримжаалан тогтоох оролдлогыг хийж байна. Бидний харьцуулсан

судалгааны явцаас үзэхэд Алаг-Өндөрийн “завьт” хүмүүсийн дүрслэл хүрэл зэвсгийн эхэн шатанд, том цээжтэй адуу болон бусад араатан амьтдын дүрслэл хүрэл зэвсгийн хөгжингүй үед, морьтон, нохой дагуулан адуу хөтөлсөн хүн хүрэл зэвсгийн хожуу шатанд, Морьтны өмнө дүрслэгдсэн хүн төмөр зэвсгийн сүүл үед, Тахилгат цагааны янгир болон тамга дундад эртний улсуудын үед (VII-VIII зуун) холбогдмоор байна.

*Талархал.* Их Нартын чулууны археологийн дурсгалыг бүртгэн баримтжуулах археологийн судалгааны ажлыг санаачлан хэрэгжүүлэх үйл хэргийн эхлэлийг тавьсан академич Т.Галбаатар, доктор С.Амгаланбаатар, АНУ-ын Денверийн Зоологийн сангийн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан доктор Р.Рыдинг (R.Reading), 2013 оны археологийн судалгааг бүх талаар дэмжин тусалсан доктор Ж.Ганчимэг (Gana Wingard), Монголын ховор амьтныг хамгаалах эвслийн гүйцэтгэх захирал Т.Сэлэнгэ, Eartwatch хүрээлэн, хадны зургийн байрлах газрын нэрийн талаар мэдээлэл өгсөн ИНБНГ-ын Хамгаалалтын захиргааны дарга Т.Анандпүрэв, хадны зургийг бүртгэн баримтжуулах ажилд тусалсан археологич С.Далантай, Г.Олзбаяр, Г.Дүгэрсүрэн, П.Хадел нарт чин сэтгэлийн талархлаа дэвшүүлье.

### НОМ ЗҮЙ

- Гантулга Ж., Ерөөл-Эрдэнэ Ч., Магай Ж. 2018. *Хөрөөгийн үзүүрийн хадны зургийн судалгаа*. Улаанбаатар: “Мөнхийн үсэг” хэвлэлийн үйлдвэр.
- Диков Н.Н. 1971. *Наскальные загадки древней Чукотки*. (Петроглифы Пегтымеля). – Москва.
- Дорж Д., Новгородова Э.А. 1975. *Петроглифы Монголии*. Улаанбаатар.
- Кубарев В.Д. 2009. *Петроглифы Шивэт-Хайрхана (Монгольский Алтай)*. Новосибирск.
- Кубарев В.Д. 2011. *Петроглифы Калбак Таша*. Новосибирск.
- Кубарев В.Д., Цэвээндорж Д., Якобсон Э. 2005. *Петроглифы Цагаан салаа и Бага-Ойгур*. Новосибирск.
- Куликова А.С. 2014. *Изображения лодок северной Евразии*. Вестник Кемеровского государственного университета. № 2 (58) Т. 2. Тал 58-69.
- Мартынов А.И. 1966. *Лодки в страну предков*. – Кемерова.
- Мөнхтулга Р, Бүрэнтөгс Г., Арьяажав Б. 2019. *Талын хөшөөний тахилын онгон*. Улаанбаатар.
- Окладников А.П. 1968. *Лики древнего Амура. Петроглифы Сакачи-Аяна*. Новосибирск.
- Окладников А.П. 1980. *Петроглифы Центральной Азии. Ховд сомон (гора Тэби)*. Ленинград.



Окладников А.П. 1981. *Петроглифы Монголии*. Ленинград.

Окладников А.П., Мазин А.И. 1976. *Писаницы Олёкмы и Верхнего Приамурья*. Новосибирск,

Окладников А.П., Мазин А.И. 1979. *Писаницы бассейна реки Алдан*. Новосибирск.

Окладников А.П., Мартынов А.И. 1972. *Сокровища Томских писаниц*. Москва.: Искусство. 255 с.

Санжмятав Т. *Монголын хадны зураг*. Улаанбаатар.

Сэр-Оджав Н. 1987. *Баянлигийн хадны зураг*. Улаанбаатар.

Цэвээндорж Д. 2020. *Монголын эртний урлагийн дурсгал*. Улаанбаатар.

Цэвээндорж Д., Батболд Н. 2005. *Дундговь аймгийн Дэл уулын Билүүний хадны зураг*. Улаанбаатар.

Цэрэндагва Я., Цэвээндорж Д. 2025. *Их Баян уулын Бичигтийн амны хадны зураг*. Улаанбаатар.

Цэрэндагва Я., Шнейдер Ж., Далантай С. 2014. *Их Нартаас илэрсэн хадны оршуулгын дурсгалууд*. – Археологийн судлал. Т. XXXIV. Fasc. 5. Улаанбаатар. Тал 329-343.

Цэрэндагва Я., Далантай С., Ундрал Б., Фаркухар Ж., Шнейдер Ж. 2020. *Зулэгтийн арын шинэ чулуун зэвсгийн дурсгалт газар*. – Археологийн судлал. Том XXXIX. Fasc. 13. 137-144. Улаанбаатар.

Цэрэндагва Я., Шнейдер Ж. 2014. *Их Нартын Байгалийн Нөөц газрын археологийн дурсгалыг бүртгэн судлах Монгол-Америкийн хамтарсан экспедицийн 2013 оны археологийн малтлага судалгааны ажлын товч үр дүнгээс*. – Монголын археологи-2013 (ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн 2013 оны хэрийн судалгааны үр дүн). Улаанбаатар. Тал 23-27.

Цэрэндагва Я., Шнейдер Ж., Далантай С. 2015. *Их Нартын Байгалийн Нөөц газрын археологийн дурсгалыг бүртгэн судлах Монгол-Америкийн хамтарсан экспедицийн 2014 оны судалгааны ажлын товч үр дүн*. – Монголын археологи-2014 (ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн 2014 оны хэрийн судалгааны үр дүн). Улаанбаатар.

Цэрэндагва Я., Шнейдер Ж., Розен А., Фаркухар Ж., Далантай С., Хадел П., Гиллиланд С., Төрбат Р., Олзбаяр Г. 2016. *Их Нартын Байгалийн Нөөц газрын археологийн дурсгалыг бүртгэн судлах Монгол-Америкийн хамтарсан экспедицийн 2015 оны судалгааны ажлын товч үр дүн*. – Монголын археологи-2015 (ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн 2015 оны хэрийн судалгааны үр дүн). Улаанбаатар. Тал 41-47.

Цэрэндагва Я., Шнейдер Ж., Розен А., Коннорс Р., Далантай С., Фаркухар Ж., Хадел П., Төрбат Р., Гиллиланд С., Чиолек-Торелло Р., Олзбаяр Г. 2017. *Монгол-Америкийн хамтарсан экспедици:*

*Их Нартын байгалийн нөөц газарт хийсэн археологийн судалгаа*. – Монголын археологи-2016. Улаанбаатар. Тал 28-36.

Цэрэндагва Я. 2020. *Ацын бууцны хадан дахь зосон зургийн дурсгал*. – Археологи, түүх, угсаатан судлалын сэтгүүл (Journal of the Archaeology, History and Ethnography). Vol. 16 (15). Тал 39-43. Улаанбаатар.

Schneider J., Hart T.C., Rosen A., Spiro A., Tserendagva Ya. 2016. *Mongolian Neolithic and Early Bronze age ground-stone tools from the northern edge of the Gobi Desert*. – Journal of Lithic studies. Vol.3, nr.3 pp. xx-xx. <https://doi.org/10.2018/jls.v3i3.1641>.

Shneider J., Tserendagva Ya., Farquhar J., Hadel P. 2019. *Entering new territory: The results of a random-sample archaeological inventory at Ikh Nartiin Chuluu Nature Reserve, Dornogovi aimag, Mongolia*. – *Archaeological Research in Asia*. <https://doi.org/10.1016/j.ara.2020.100251>.

Rosen A., Hart T., Farquhar J., Schneider J., Tserendagva Ya. *Holocene vegetation cycles, land use, and human adaptations to desertification in the Gobi Desert of Mongolia - Vegetation History and Archaeobotany*. 28:295-309. <https://doi.org/10.1007/s00334-018-0710-y>.

## REFERENCES

Gantulga J., Yuruul-Erdene Ch., Magail J. 2018. *Huruugiin uzuuriyn khadniy zurgiyн sudalгаа* [Research Study of Rock Art Khuruugiin uzuur]. - Ulaanbaatar: “Munkhiin useg” Publishing.

Dikov N.N. 1971. *Naskal'nie zagadki drevnei Chukotki (Petroglify Pegtemelya)* [Rocky Enigmas of Ancient Chukoka (Petroglyphs of Pegtymel river)]. Moscow.

Dorj D., Novgorodova E.G. 1975. *Petroglify Mongolii* [Petroglyphs of Mongolia]. Ulaanbaatar.

Kubarev V.D. 2009. *Petroglifi Shivet-Khairkhana (Mongol'skii Altay)* [Petroglyphs of Shivet-Khairkhan (Mongolian Altay)]. Novosibirsk.

Kubarev V.D. 2011. *Petroglifi Kalbak Tasha* [Petroglyphs of Kalbak Tash]. Novosibirsk.

Kubarev V.D., Tseveendorj D., E.Jacobson. 2009. *Petroglifi Tsagaan-Salaa and Baga-Oigur*. [Petroglyphs Tsagaan-Salaa and Baga-Oigur]. Novosibirsk.

Kulikova A.S. 2014. *Izobrajeniya lodok severnoi Evrazii* [Images of boats in Northern Eurasia]. Vestnik Kemerovskogo gosudarstvennogo universiteta. № 2 (58) T. 2. Pp. 58-69.

Martynov A.I. 1966. *Lodki v stranu predkov* [Boats to the Land of Ancestors]. Kemerova.

Munkhtulga R., Burentugs G., Ariyajav B. 2019. *Taliin hushuunii takhiliin ongon* [Memorial Steles of Taliin Khushuu]. Ulaanbaatar.

Okladnikov A.P. 1968. *Liki drevnego Amura. Petroglifi Sakachi-Alyana* [Masks of Ancient Amur.

Petroglyphs of Sakachi-Alyan]. Novosibirsk.

Okladnikov A.P. 1980. *Petroglifi Tsentral'noi Azii. Khovd somon (gora Tevsh)* [Petroglyphs of Central Asia. Khovd somon (Mount Tevsh)]. Leningrad.

Okladnikov A.P. 1981. *Petroglifi Mongoliy* [Petroglyphs of Mongolia]. Leningrad.

Okladnikov A.P., Mazin A.I. 1976. *Pisanitsy Olyokmy i Verkhnego Priamurya* [Rock Paintings of Olyokma river and Priamurye]. Novosibirsk.

Okladnikov A.P., Mazin A.I. 1979. *Pisanitsy basseina reki Aldan* [Rock Paintings of valley river Aldan]. Novosibirsk.

Okladnikov A.P., Martynov A.I. 1972. *Sokrovisha Tomskikh pisanits* [The Treasure Trove of Tom Petroglyphs]. Moscow, 255 p.

Sanjmyatav T. *Mongoliin khadnii zurag* [Petroglyphs of Mongolia]. Ulaanbaatar.

Ser-Odjav N. 1987. *Baynligiin khadnii zurag* [Petroglyphs of Bayanlig]. Ulaanbaatar.

Tseveendorj D. 2020. *Mongoliin ertnii urlagiin dursgal* [Ancient Monuments of Art Mongolia]. Ulaanbaatar.

Tseveendorj D., Batbold N. 2005. *Dundgovi aimgiin Del uuliin Biluunii khadnii zurag* [Rock Art of Biluun, Del mountain, Dundgovi aimag]. Ulaanbaatar.

Tserendagva Ya., Tseveendorj D. 2025. *Ikh Bayan uuliin Bichigtiin amniy khadnii zurag* [Petroglyphs of the Bichigt valley of Ikh Bayan Mount]. Ulaanbaatar: Admon Publishing.

Tserendagva Ya., Schneider J., Dalantai S. 2014. *Ikh Nartaas ilersen khadniiy orshuulgiin dursgaluud* [Newly discovered cave burials at Ikh Nart]. *Studia Archaeologica*. T. XXXIV. Fasc. 5. Ulaanbaatar. pp. 329-343.

Tserendagva Ya., Dalantai S., Undral B., Farquhar J., Schneider J. 2020. *Zulegtiin ariyn shine chuluun zewsgiin dursgal gazar* [The newly found Neolithic Site of Zulregtiin Ar]. - *Studia Archaeologica*. T. XXXIX. Fasc. 13. Ulaanbaatar. pp. 137-144.

Tserendagva Ya., Schneider J. 2014. *Ikh Nartiyn Baigaliyn Nuuts Gazriyn arkeologiiin dursgaliig burtgen sudlakh Mongol-Amerikiyn khamtarsan ekspeditsiyn 2013 onii arkeologiiin maltlaga sudalgaaniy ajliyn tovch ur dungees* [Preliminary Result of Archaeological Studies carried out by the Join Mongolian-American expedition in Ikh Nart Nature Reserve, Mongolia in 2013] – *Mongolian Archaeology-2013*. Ulaanbaatar, pp. 23-27.

Tserendagva Ya., Schneider J., Dalantay S. 2015. *Ikh Nartiyn Baigaliyn Nuuts Gazriyn arkeologiiin dursgaliig burtgen sudlakh Mongol-Amerikiyn khamtarsan ekspeditsiyn 2014 onii arkeologiiin maltlaga sudalgaaniy ajliyn tovch ur dungees* [Preliminary Result of Archaeological Studies carried out by the Join Mongolian-American expedition in Ikh Nart Nature Reserve, Mongolia in 2014] – *Mongolian*

*Archaeology-2014*. Ulaanbaatar.

Tserendagva Ya., Schneider J., Rosen A., Farquhar J., Dalantai S., Hadel P., Gilliland S., Turbat R., Olzbayar G. 2016. *Ikh Nartiyn Baigaliyn Nuuts Gazriyn arkeologiiin dursgaliig burtgen sudlakh Mongol-Amerikiyn khamtarsan ekspeditsiyn 2015 onii arkeologiiin maltlaga sudalgaaniy ajliyn tovch ur dungees* [Preliminary Result of Archaeological Studies carried out by the Join Mongolian-American expedition in Ikh Nart Nature Reserve, Mongolia in 2015] – *Mongolian Archaeology-2015*. Ulaanbaatar, pp. 41-47.

Tserendagva Ya., Schneider J., Rosen A., Connors R., Dalantai S., Farquhar J., Hadel P., Turbat R., Gilliland S., Chiolek-Torello P., Olzbayar G. 2017. *Mongol Amerikiyn khamtarsan ekspeditsi: Ikh Nartiyn Baigaliin nuuts gazart hiisen ar[eologiiin sudalгаа* [Joint Mongolian-American expedition: Archaeological studies in Ikh Nart Nature Reserve]. - *Mongolian Archaeology-2017*. Ulaanbaatar, pp. 28-36.

Tserendagva Ya. 2020. *Atsiin buutsnii khadan dah' zoson zurgiiin dursgal* [Rock painting with ochre in Atsiin buuts rock]. - *Journal of the Archaeology, History and Ethnography*. Vol. 16 (15). pp. 39-43. Ulaanbaatar.

Schneider J., Hart T.C., Rosen A., Spiro A., Tserendagva Ya. 2016. *Mongolian Neolithic and Early Bronze age ground-stone tools from the northern edge of the Gobi Desert*. - *Journal of Lithic studies*. Vol.3, nr.3 pp. xx-xx. <https://doi.org/10.2018/jls.v3i3.1641>.

Shneider J., Tserendagva Ya., Farquhar J., Hadel P. 2019. *Entering new territory: The results of a random-sample archaeological inventory at Ikh Nartiin Chuluu Nature Reserve, Dornogovi aimag, Mongolia*. - *Archaeological Research in Asia*. <https://doi.org/10.1016/j.ara.2220.100251>.

Rosen A., Hart T., Farquhar J., Schneider J., Tserendagva Ya. *Holocene vegetation cycles, land use, and human adaptations to desertification in the Gobi Desert of Mongolia* - *Vegetation History and Archaeobotany*. 28:295-309. <https://doi.org/10.1007/s00334-018-0710-y>.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution

Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>